



ХЭНТИЙ АЙМГИЙН
МӨРӨН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 01 сарын 05 өдөр

Дугаар 5/03

Мөрөн сум

Э.Балчиндоржийг сумын Засаг даргын
орлогчоор томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 59 дүгээр зүйлийн 59.1.22 дахь хэсэг, Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолын 12 дахь хавсралт, Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 82 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын Засаг даргын орлогчийн албан тушаалд (Энхболдын Балчиндорж)-ийг томилоход Авлигатай тэмцэх газрын 05/20244 тоот албан бичгээр татгалзах шалтгаан тогтоогдоогүй тул 2026-оны 01 дүгээр сарын 05-ны өдрөөс эхлэн томилсугай.

2.Засаг даргын орлогч (Э.Балчиндорж)-ийн үндсэн цалинг ТУТ-1 982 000 (Нэг сая есөн зуун наян хоёр мянга) төгрөгөөр, бусад нэмэгдлүүдийг хууль журмын дагуу бодож олгохыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Б.Нандин-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.

3.Сумын Засаг даргын орлогчийн албан тушаалд томилогдсон (Э.Балчиндорж)-д хуулиар хүлээсэн эрх, үүргийг хэрэгжүүлж ажлын гүйцэтгэлдээ бүрэн хариуцлага хүлээж ажиллахыг даалгасугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Намжилноров)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Н.ХАТАНБААТАР